

Үндэсний статистикийн хорооны
дарга, Нийгмийн хамгаалал,
хөдөлмөрийн сайдын, 2010 оны 4
дүгээр сарын 05 -ны өдрийн 58/36
тоот хамтарсан тушаалын 1 дүгээр
хавсралт

ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГААР ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Улаанбаатар хот

2010 он

АГУУЛГА

- I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
- II. ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГААР ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛД АШИГЛАГДАХ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ
- III. ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГААР ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР
 - III.1. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалын зорилго, хамрах хүрээ
 - III.2. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалд баримтлах зарчим
 - III.3. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэр
 - III.4. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах, мэдээллийн сан байгуулах, санал, гомдол барагдуулах систем
- IV. ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГААР ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ
- V. АРГАЧЛАЛЫН ДАГУУ ХИЙСЭН ТООЦООНЫ ҮР ДҮНГ ХЭРЭГЛЭХ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох, нийгмийн хамгааллын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай болох, нийгмийн хамгааллын хөтөлбөр, арга хэмжээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх арга зүй, зохион байгуулалтыг сайжруулах¹”-аар тусгагдсаны дагуу нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх, тэдгээрт улсын төсвөөс зарцуулж байгаа хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Дээрхи зорилтын хүрээнд орлогыг орлуулан тооцох аргаар нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай зорилтот өрхийг тодорхойлж, салбар дундын мэдээллийн нэгдсэн сан байгуулах зорилгоор энэхүү аргачлалыг “Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгаа”-ны мэдээллийн сан дээр үндэслэн тухайн судалгааны үзүүлэлт, ойлголт, тодорхойлолттой нийцүүлэн боловсруулав.

Энэ аргачлалыг хэрэглэснээр зорилтот өрхүүдийг нийгмийн халамжийн аливаа тусламж, үйлчилгээнд илүү бодитой хамруулах, холбогдох бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зорилтот бүлгийг тодорхойлоход шаардлагатай цахим мэдээллийн санг өрхөөр бий болгох боломжийг бүрдүүлэх юм.

¹ Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 1.4.1 болон 1.4.11 дэх заалтаас

ХОЁР. ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГААР ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛД АШИГЛАГДАХ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалд хэрэглэгдэж буй ойлголт, тодорхойлолтыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

II.1. Хамгийн бага квадратын арга: Хувьсах үзүүлэлтүүдийн бодит утга болон үнэлгээний утгуудын зөрүүний квадратуудын нийлбэр нь хамгийн бага байх үеийн итгэлцүүр;

II.2. Коэффициент: Регрессийн загварт ашигласан тайлбарлагч хувьсагчийн үнэлэгдсэн утга;

II.3. Тогтмол тоо: Шугаман регрессийн загварт ашигласан үзүүлэлтүүдийн нэг бөгөөд өрхийн хэрэглээний зардлын тогтмол хэсгийн утга;

II.4. Өрхийн тооны тэнцүү 10 бүлэг: Өрхүүдийг нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр нь багаас нь их уруу нь эрэмбэлэн, энэхүү өрхийн тоог 10, 10 хувиар буюу тэнцүү 10 бүлэгт хувааж, бүлэглэсэн байдал;

II.5. Байршил: Тухайн өрхийн харъяалагдаж байгаа засаг, захиргааны нэгж, (аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хороо);

II.6. Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин: Тухайн өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын хамгийн дээд түвшин;

II.7. Хөдөлмөр эрхлэлт: Өрхийн 10 ба түүнээс дээш насны гишүүдийн сүүлийн 12 сарын хугацаанд хөдөлмөр эрхэлсэн байдал;

II.8. Орон сууцны төрөл: Өрхийн амьдарч буй сууцны төрөл.

II.9. Дээврийн үндсэн материал: Өрхийн амьдарч буй сууцны дээвэр талыг бүрсэн материал;

II.10. Сууцны өрөөний тоо: Өрхийн амьдарч буй сууцны (гал тогоо, коридор болон ариун цэврийн өрөөг тооцохгүй) өрөөний тоо;

II.11. Гэрийн ханын тоо: Өрхийн амьдарч буй гэрийн ханын тоо;

II.12. Гэрийн дээвэр: Өрхийн гэрийн дан болон давхар дээвэр, туурга;

II.13. Цахилгаан: Өрхийн гэрэлтүүлэгтээ ашигладаг цахилгааны эх үүсвэр;

II.14. Халаалт: Өрхийн дулаан хангамжийн үндсэн эх үүсвэр;

II.15. Ундны усны эх үүсвэр: Өрхийн ундны хэрэглээндээ хэрэглэж байгаа усны эх үүсвэр;

II.16. Бохирын систем: Тухайн өрхийн сууцны бохир усны шугам хоолой, эсвэл бохир усны зориулалтын цооног;

II.17. Харилцуур утас: Өрхийн суурин болон хөдөлгөөнт харилцуур утас;

II.18. Хамгийн ойр ЕБ-ын сургууль хүртэлх зай: Өрхөөс хамгийн ойр байрлах ерөнхий боловсролын сургууль хүртлэх зай;

II.19. Мал аж ахуй эрхэлдэг эсэх: Өрх сүүлийн 12 сард мал аж ахуй эрхэлсэн байдал;

II.20. Малын тоо толгой: Таван хошуу малын тоо;

II.21. Удаан эдэлгээтэй эд хогшил: Өрхөд байгаа зөвхөн ашиглагддаг удаан эдэлгээтэй эд хогшил.

**ГУРАВ. ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГААР ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ
ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ,
БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ДАРААЛАЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР**

III.1. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалын зорилго, хамрах хүрээ

III.1.1. Зорилго

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалын зорилго нь өрхийн амьжиргааны түвшинг шууд илэрхийлэх, орлогын талаарх мэдээлэл, арга, аргачлал байхгүй үед түүнийг орлохуйц үзүүлэлтүүдийг ашиглан амьжиргааны түвшний үнэлгээ хийж, үр дүнг үндэслэн нийгмийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай зорилтот бүлгийг тодорхойлох, зорилтот бүлгийн талаархи үндэсний хэмжээний цахим мэдээллийн сан байгуулахад оршино.

III.1.2. Хамрах хүрээ

Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төв, хөдөө гэсэн дөрвөн байршлаар тооцож, дараах байдлаар хамруулна. Үүнд:

1. Улаанбаатар хотын гэр хорооллын бүх өрх мөн орон сууцны хорооллын өргөдлөө өгч амьжиргааны түвшнээ үнэлүүлэх хүсэлт гаргасан өрхүүд;
2. Аймгийн төвийн гэр хорооллын бүх өрх мөн орон сууцны хорооллын өргөдлөө өгч амьжиргааны түвшнээ үнэлүүлэх хүсэлт гаргасан өрхүүд;
3. Сумын төвийн багийн өргөдлөө өгч амьжиргааны түвшнээ үнэлүүлэх хүсэлт гаргасан өрхүүд;
4. Хөдөөгийн багийн бүх өрхүүдийг тус тус хамруулна.

III.2. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалд баримтлах зарчим

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлоход дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- III.2.1. Үзүүлэлтүүд нь өөр хоорондоо холбоо, хамааралтай байх;
- III.2.3. Шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйтэй байх;
- III.2.4. Мэдээллийн эх үүсвэр тодорхой, мэдээлэл нь тогтмол, үнэн бодитой байх;
- III.2.5. Үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байх;
- III.2.6. Хэмжих боломжтой, тодорхой үзүүлэлтийг сонгосон байх;
- III.2.7. Статистикийн хувьд ач холбогдолтой байх;
- III.2.8. Эрэмбэлэх боломжтой аж байдлын үзүүлэлт байх.

III.3. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэр

Тооцоонд Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг ашиглана.

III.4. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах, мэдээллийн сан байгуулах, санал, гомдол барагдуулах систем

III.4.1. Мэдээлэл цуглуулах

Мэдээлэл цуглуулах ажлыг батлагдсан асуулгын хуудас, түүнийг нөхөх зааврын дагуу давтамжтайгаар хөндлөнгийн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

III.4.2. Мэдээллийн боловсруулалт, мэдээллийн сан байгуулалт

Цуглуулсан мэдээллийг цаасан болон электрон хэлбэрээр НХХЯ хүлээн авч энэхүү аргачлалд зориулан тусгайлан боловсруулсан боловсруулалтын “ООТС-1” программыг ашиглан боловсруулалтуудыг хийж, мэдээллийн санг өрхөөр, байршлаар бий болгоно. Үүний зэрэгцээ лавлагаа болгон өрхийн судалгаанд хамрагдахаар хүсэлт гаргасан өргөдлийн, өрхийн асуулгын нөхөгдсөн хуудас, болон санал, хүсэлт барагдуулах маягтуудын цахим хувилбарыг мэдээллийн санд архивлан хадгална.

III.4.3. Мэдээллийг шинэчлэх давтамж

Мэдээллийн санг 3 жилд нэг удаа Өрхийн нийгэм эдийн засгийн дэлгэрэнгүй судалгааны давтамжтай ижил хугацаанд шинэчлэнэ.

III.4.4. Хяналт үнэлгээ ба санал гомдол барагдуулах систем

III.4.4.1. Өрхийн мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээлэл цуглуулах үеийн мэдээллийн ажлын чанарт хяналт тавих, найдвартай байдлыг хангах зорилгоор хяналт, үнэлгээг НХХЯ-наас батласан тусгай удирдамжийн дагуу хамтарсан ажлын хэсэг гүйцэтгэнэ.

III.4.4.2. Өрхөөс мэдээлэл цуглуулах явцад энэ судалгаанд хамрагдвал зохих өрхүүдээс орхигдсон эсвэл хамрагдахгүй өрхийг хамруулсан талаархи санал, гомдлыг НХХЯ-наас батласан өргөдлийн дагуу хөндлөнгийн мэргэжлийн байгууллага хүлээн авч тухайн өрхийн хүсэлтийн дагуу өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох ажлыг санал, гомдол барагдуулах ажлын хүрээнд гүйцэтгэнэ.

III.4.4.3. Мэдээллийн сан байгуулагдсаны дараа тухайн өрх өөрийн амьжиргааны түвшнээ тогтоолгох хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд НХХЯ-наас батласан өргөдлийн дагуу гаргана. Өрхийн амьжиргааг үнэлэх үйл ажиллагааг НХХЯ хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр зохион байгуулна.

III.4.4.3. Санал, гомдол барагдуулах өргөдлийн маягтыг НХХЯ-наас баталж, мөрдүүлнэ.

ДӨРӨВ. ОРЛОГЫГ ОРЛУУЛАН ТООЦОХ АРГААР ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ

Орлогыг орлуулан тооцох арга нь өрхийн амьжиргааг сонгогдсон багц хувьсах үзүүлэлтүүдээр загвар боловсруулж, тооцох арга болно. Өрхийн амьжиргаанд нөлөө бүхий үзүүлэлтүүдийг багцаар авч үзэх нь амьжиргааны түвшинг илүү сайн харуулдаг.

Хувьсах үзүүлэлтийг сонгох: ҮСХ-ноос явуулдаг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанаас дараах шаардлага хангасан хувьсах үзүүлэлтүүдийг сонгоно. **Үүнд:**

- Өрхийн орлоготой (*нэг хүнд ноогдох хэрэглээтэй*) илүү хамааралтай;
- Мэдээллийг өрхөөс асуулгын аргаар хялбар цуглуулж шинэчилж болох;
- Судалгааны тоологч нар нягтлан шалгахад хялбар;
- Тухайн үзүүлэлт нь богино хугацаанд өөрчлөлт бага гарах буюу харьцангуй тогтвортой байх;

Хувьсах үзүүлэлтийн коэффициентийг тооцох²: Хувьсах үзүүлэлтийн коэффициентийн тоон утгыг олон хүчин зүйлийн регрессийн загвараар дараах томъёогоор тооцоолно.

$$\ln Y = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \beta_n X_n + \varepsilon$$

Энд:

$\ln Y$	Тухайн үзүүлэлтийн нөлөөллийг (Нэг хүнд ногдох хэрэглээний логарифмтай уялдуулсан) илэрхийлсэн коэффициент;
β_0	Тогтмол тоо;
β_1, \dots, β_n	Коэффициентууд (<i>Үнэлэгдсэн утга</i>);
X_1, \dots, X_n	Хувьсах үзүүлэлтүүд (<i>Өгөгдсөн утга</i>);
ε	Тооцооллын алдаа.

Хувьсах үзүүлэлтүүдийн хувьд статистик ач холбогдлыг шалгаж, үнэлэх: Энэ аргачлал нь хувьсах үзүүлэлтийн коэффициентуудын статистик ач холбогдлыг шалгана. Өөрөөр хэлбэл, статистик ач холбогдолгүй (ач холбогдлын коэффициент 5%-с бага) үзүүлэлтүүд хасагдана. Дээрх үйлдлийг хамааралтай үзүүлэлтийн багц бүрээр давтан тооцох замаар статистик ач холбогдолтой үзүүлэлтүүд сонгогдож, итгэлцүүрийн утга тооцоологдоно. Статистикийн хувьд ач холбогдолгүй, хасагдсан хувьсах үзүүлэлтүүдийн утгыг тогтмол тоонд (β_0) оруулж тооцно.

Амьжиргааны түвшний өрхийн коэффициент³: Статистик ач холбогдолтой үзүүлэлтүүдээр /тогтмол тоо, тооцооллын алдааны утгыг оруулан/ нэг хүнд ногдох хэрэглээний түвшинг тооцно.

² Хувьсах үзүүлэлтүүдийн коэффициентуудыг нийтэд ил гаргахгүй нууцлана.

³ Хувьсах үзүүлэлтүүдийн коэффициентуудыг нийтэд ил гаргахгүй нууцлана.

$$\ln Y = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \beta_n X_n + \varepsilon$$

Энд:

$\ln Y$	Тухайн өрхийн амьжиргааны түвшинг илэрхийлсэн (Нэг хүнд ногдох хэрэглээний логарифмтай уялдуулсан) коэффициент;
β_0	Тогтмол тоо;
β_1, \dots, β_n	Кoeffициентууд (Үнэлэгдсэн утга);
X_1, \dots, X_n	Хувьсах үзүүлэлтүүд (Өгөгдсөн утга);
ε	Тооцооллын алдаа.

Өрхийн тооны тэнцүү 10 бүлэг: Нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр нь өрхийг багаас нь их уруу нь эрэмблэн, улмаар 10, 10 хувиар буюу тэнцүү 10 бүлэгт хуваана.

Статистик ач холбогдолтой үзүүлэлтүүдийн коэффициентийг регрессийн дээрхи томъёонд орлуулан тухайн өрхийн нэг хүнд ногдох хэрэглээгээр амьжиргааны түвшинг тодорхойлж, тэнцүү 10 бүлгээр дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1.

Өрхийн тооны тэнцүү 10 бүлэг	Амьжиргааны түвшний коэффициент ⁴ (Нэг хүнд ногдох хэрэглээ)
1 (Хамгийн бага хэрэглээтэй)	10,1
2	10,5
3	10,8
4	11,0
5	11,1
6	11,3
7	11,5
8	11,7
9	12,0
10 (Хамгийн их хэрэглээтэй)	12,5

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг нэг өрхийн түвшинд тодорхойлсон хийсвэр жишээг хавсралт 1-ээс харна уу.

⁴ Амьжиргааны түвшний 10 бүлгийг тодорхойлж байгаа коэффициент нь цаашид тодорхой хугацааны дараа бодит мэдээлэлтэй уялдан өөрчлөгдөх болно.

ТАВ. АРГАЧЛАЛЫН ДАГУУ ХИЙСЭН ТООЦООНЫ ҮР ДҮНГ ХЭРЭГЛЭХ

V.1. Энэ аргачлалын дагуу байгуулсан мэдээллийн санг бодлого боловсруулахад болон нийгмийн аливаа тусламж, үйлчилгээг хүргэх зорилтот хүрээг тогтоох, тусламж, үйлчилгээний төрөл, хэлбэр, хэмжээг тодорхойлоход зориулсан зохистой бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглана.

V.2. Мэдээллийн сангийн найдвартай байдал, нууцлалыг НХХЯ хариуцаж, боловсрол, эрүүл мэндийн салбарын чиглэлийн бодлого, төслийн хэрэгжилт, зохих тусламж, үйлчилгээнүүдэд нэгэн адил ашиглана.

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг
тооцох хийсвэр жишээ

Улаанбаатар хотод амьдардаг, 3 ам бүлтэй, ажил эрхэлдэг 2 гишүүнтэй, 0-5 насны нэг хүүхэдтэй, өрхийн тэргүүн нь дээд боловсролтой, 5 ханатай, давхар дээвэртэй гэрт амьдардаг, цахилгаан хэрэглэдэг, хөргөгч, тоос сорогч, индүү, өнгөт телевизор зэрэг эд хогшилтой, гар болон суурин утастай, халаалтандаа нүүрс хэрэглэдэг айлыг авч үзвэл, өрхийн амьжиргааны түвшний үнэлгээг дараах байдлаар тооцно. (Хариулт “Тийм” бол -1, “Үгүй” бол-0 гэж тэмдэглэнэ.)

№	ХУВЬСАГЧУУД	УБ ХОТ	ХАРИУЛТ	ҮНЭЛГЭЭ
		КОЭФ		
1. ӨРХИЙН ТЭРГҮҮНИЙ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН				
	Мэргэжлийн болон түүнээс дээшхи боловсрол	0.0825	1	0.0825
2. ӨРХИЙН АМ БҮЛИЙН ТОО				
	2	-0.4397	0	0
	3	-0.6938	1	-0.6938
	4	-0.8867	0	0
	5	-1.0445	0	0
	6	-1.1524	0	0
	7 болон түүнээс дээш	-1.2656	0	0
3. ӨРХИЙН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ				
	0 - 5 настай гишүүдийн тоо	-0.1251	1	-0.1251
	6 - 14 настай гишүүдийн тоо	-0.0594	0	0
4. ӨРХИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ГИШҮҮДИЙН ТОО				
	1	0.1221	0	0
	2	0.1958	1	0.1958
	3	0.2101	0	0
	4 ба түүнээс дээш	0.3710	0	0
5. ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ				
	Орон сууцны доторхи сууц	0.1508	0	0
	Өрөөний тоо (г эр бол "0")	0.0693	0	0
6. ҮЙЛЧИЛГЭЭ				
	Халаалтандаа нүүрс хэрэглэдэг эсэх	-0.0913	1	-0.0913
	Телефон утас (суурин болон гар)	0.3219	1	0.3219
7. ЭД ХОГШИЛ				
	Хөргөгч	0.1054	1	0.1054
	Тоос сорогч	0.0810	1	0.0810
	Угаалгын машин	0.1340	0	0
	Цахилгаан зуух (эсвэл хийн зуух)	0.0720	0	0
	Ачааны машин	0.3174	0	0
	Суудлын машин	0.3542	0	0
8. ТОГТМОЛ ТОО		11.5877		11.5877
АМЬЖИРГААНЫ ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ				11.4641
АМЬЖИРГААНЫ ТҮВШИН				VI

$$LnY = 11.5877 + 0.0825 - 0.6938 - 0.1251 + 0.1958 - 0.0913 + 0.3219 + 0.1054 + 0.0810 = 11.4641$$

Ашигласан материал

- 1) “Нийгмийн халамжийн тухай” хууль., уб., 2007 он
- 2) “Монгол улсын засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”., УБ., 2008 он
- 3) Каридад Араужо., Людовико Карраро., Лучилла Бруни., “Монгол улсад хэрэгжиж буй ядуурлыг бууруулах төсөл, хөтөлбөрийн зорилтот бүлгүүдийг тодорхойлоход орлогыг орлуулан тооцоолох аргыг (ООТА) хэрэглэх нь баримт бичиг”., Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк., 2009 он
- 4) Людовико Карраро., “Монгол улсад орлогыг орлуулан тооцох аргыг хэрэглэх үзэл баримтлал”., АХБ., 2009 он
- 5) Каридад Араужо., “Хүүхдийн мөнгөний хөтөлбөрт зорилтот бүлгийг тодорхойлсон төлөв байдалд хийсэн үнэлгээ”-ний тайлан., Дэлхийн банк., 2006., 4 сар
- 6) М, А Грош, Ж.Бэйкэр., “Нийгмийн тусламжид хамрагдах зорилтот бүлгийг орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлох нь”., Дэлхийн банк., 1995 он.
- 7) <http://web.worldbank.org/wbsite/external/topics/extsocialprotection/extsafetynetsandtransfers/0,,contentmdk:20795790~iscurl:y~menupk:1552914~pagepk:210058~pipk:210062~thesitepk:282761.00.html> proxy means testing (pmt)
- 8) <http://web.worldbank.org/wbsite/external/topics/extsocialprotection/extsafetynetsandtransfers/0,,contentmdk:21872947~pagepk:148956~pipk:216618~thesitepk:282761.00.html> safety nets primer resources - proxy means testing, designing and implementing household targeting systems: lessons from latin american and the united states
- 9) <http://web.worldbank.org/wbsite/external/topics/extsocialprotection/extsafetynetsandtransfers/0,,contentmdk:20808132~pagepk:210058~pipk:210062~thesitepk:282761.00.html>, targeting works! Lessons from the europe & central asia region